



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 395

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 41,100,000.00 (дөчин нэгэн сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 9,247,500.00 (есөн сая хоёр зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын дарга Дэд хурандаа С.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, тогтоолын биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001903
19-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар 08 сарын 21-ны өдрийн
... дугаар тогтроолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв	УАЗ-Фургон /улсын дугаар 23-62 УАЕ/	8/6/2021	Ш	1	41,100,000.00	41,100,000.00	9,247,500.00	31,852,500.00
							дөчин нэгэн сая нэг зуун мянган төгрөг	есөн сая хоёр зуун дөчин долоон мянга таван зуун төгрөг	гучин нэгэн сая найман зуун тавин хоёр мянга таван зуун төгрөг